



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 1 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ НЭМЭГДҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН, 3 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ЗӨРҮҮТЭЙ ОЛГОСОН, 2 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛД БУРУУ ТУСГАСАН БАЙНА.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: УВА-2026/108/-ШТА-НА

Улаангом хот 2026 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер М.Бат-Амгалан

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Мөнхтогтох

Утас: 70453317 Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn

Аудитор Т.Золоо

Утас: 70453317 Цахим хаяг: zoloot@audit.gov.mn

Аудитор Т.Ариунсайхан

Утас: 70453317 Цахим хаяг: ariunsaikhant@audit.gov.mn

Аудитор Б.Нямбуу

Утас: 70453317 Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Open.audit.mn хаягаар авна уу.



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/17

Улаангом

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг (НТАГ-2026/108-ШТА-НА) хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Ч.Мөнхтогтох нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

8525010054

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	4-5 6
Аудитын менежер М.Бат-Амгалан	БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	8
Ахлах аудитор Ч.Мөнхтогтох	<i>1.1. Холбогдох зардлын тооцоолол хийсэн, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдсан ч, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 5 төсөл, арга хэмжээг баталсан байна.</i>	9
Аудитор Т.Золоо Т.Ариунсайхан Б.Нямбуу	<i>1.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг журмын дагуу тооцож, байгууллага, иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.</i>	10
2026 оны 5 дугаар сар	<i>1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 2 төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангасан байна.</i>	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 70453721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.	БҮЛЭГ 2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулсан ч 1 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийг 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зохион байгуулсан байна.	11
	<i>2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг батлагдсан төсвөөс 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зохион байгуулсан байна.</i>	17
	<i>2.2. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч, сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд 1 гомдол гаргасан байна.</i>	17
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	БҮЛЭГ 3. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд хэрэгжүүлсэн байна.	18
	<i>3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд хэрэгжүүлсэн байна.</i>	19
	<i>3.2 Захиалагч нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн ч эрх шилжүүлсэн 4 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.</i>	20 20
	БҮЛЭГ 4. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зөрүүтэй олгосон, 2 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд буруу тусгасан байна.	22
		22

	4.1 Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 24.9 сая төгрөгөөр илүү, 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 0.4 сая төгрөгөөр дутуу олгосон байна.	23
	4.2 Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг өмчийн бүртгэлд тусгасан ч 1 төсөл, арга хэмжээний бүртгэлийн дүн зөрүүтэй, 1 төсөл, арга хэмжээг буруу дансанд бүртгэсэн байна.	24
	ДҮГНЭЛТ	25
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	26
	АУДИТЫН ГАЗРААС ӨГӨХ ТАЙЛБАР	
	ЗӨВЛӨМЖ	30

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

УВА	УВС АЙМАГ
ШТА	ШУУД ТАЙЛАГНАХ АУДИТ
НА	НИЙЦЛИЙН АУДИТ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ОНХО	ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТАХ	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ
УТХО	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
НТШ	НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ
ХА	ХАРЬЦУУЛАЛТЫН АРГА
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ГИХГ	ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
ТӨХК	ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ШХА	ШУУД ХУДАЛДАН АВАЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдсан байдал.....	8
Хүснэгт 2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээ.....	9
Хүснэгт 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа.....	12
Хүснэгт 4. Төсөвт өртгөөс үл хамааран шууд худалдан авалт хийсэн төсөл, арга хэмжээ	14
Хүснэгт 5. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ	14
Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр болон шилжин хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ.....	16
Хүснэгт 7. Тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргасан төсөл, арга хэмжээ.....	17
Хүснэгт 8. Он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ	19
Хүснэгт 9. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ.....	20
Хүснэгт 10. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ.....	21
Хүснэгт 11. Бүрэн хэрэгжсэн ч санхүүжилт дутуу, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ.....	19
Хүснэгт 12. Бүрэн хэрэгжсэн ч санхүүжилт нь дутуу төсөл, арга хэмжээ.....	23

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 оны А/33 дугаар тушаал, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг Нийслэл дэх Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх.
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитыг аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 15, замын сангийн хөрөнгө оруулалтын 1, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 1, нийт 17 төсөл, арга хэмжээний баримт материал, ажлын тайлан, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын дүгнэлт, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хамруулан хийж гүйцэтгэлээ.

Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд санхүүжүүлэхээр баталсан 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулсан.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх,

харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Мөнхтогтох, аудитор Т.Золоо, Б.Нямбуу, Т.Ариунсайхан нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг анх аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор 4,098.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,188.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1, нийт 5,299.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ баталж, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолоор зохицуулалт хийж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,373.3 сая төгрөгийн 15, замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,188.9 сая төгрөгийн 1, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1, нийт 5,574.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ, 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор тодотгол хийж Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,053.3 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 1,188.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, нийт 5,254.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДААГҮЙ 5 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1. Холбогдох зардлын тооцоолол хийсэн, урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдсан ч, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй 5 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор “Увс аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 4 бодлогын хүрээнд 100 зорилт, 20 төсөл, арга хэмжээ, 14 шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэйгээр баталсан байна.

“Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан байна. Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 92 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс үнэлгээ хийсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”, 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Увс аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан байна.

Орон нутгийн төсвөөр 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй дараах байдлаар уялдсан байна.

Хүснэгт 1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй дараах байдлаар уялдалдсан байна.

№	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		Орон нутгийн төсвөөр 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	
2	Хүний хөгжил	7	
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	3
4	Эдийн засаг	6	3

5	Засаглал	6	2
6	Ногоон хөгжил	4	4
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	2
8	Бүс, сум, орон нутгийн хөгжил	3	3
Дүн		42	17

Эх сурвалж: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 5,254.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг баталснаас 755.1 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Үүнд:

Хүснэгт 2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагдаагүй төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	/сая.төг/ 2025 онд хэрэгжүүлэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	Засаг даргын тамгын газарт автомашины парк шинэчлэлт	2025	2025	250.0	250.0
2	Хүрэн морьтын давааны зам засвар /Малчин сумын/	2025	2025	90.0	90.0
3	Хар хэмийн амны зам засвар /Малчин сумын/	2025	2025	85.1	85.1
4	Хур хог булшлах, цэвэрлэх /Малчин сумын/	2025	2025	30.0	30.0
5	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сум 1-р баг/	2025	2025	300.0	300.0
Нийт				755.1	755.1

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө

Дээрх зөрчилд Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

1.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг журмын дагуу тооцож, байгууллага, иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 2.3.2.2-т “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг сум, байгууллага, иргэдээс авч нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн эрэмбэлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна. Үүнд;

Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 1/2165 дугаар албан бичгээр орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 4,098.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,188.9 сая

төгрөгийн төсөвт өртөгтэй 1, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1, нийт 5,299.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээний саналыг аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 2 төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангасан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,098.2 сая төгрөгийн 11, замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,188.9 сая төгрөгийн 1, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1, нийт 5,299.2 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг баталсан байна. Мөн аймгийн ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолоор төсөвт зохицуулалт хийж 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,373.3 сая төгрөгийн 15, замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,188.9 сая төгрөгийн 1, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1, нийт 5,574.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээ болгон 275.1 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн баталсан байна. Төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна”, 42.7 дахь хэсэгт “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөнд Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж өгсөн.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны төсөвт тодотгол хийхдээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,053.3 сая төгрөгийн 15, замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,188.9 сая төгрөгийн 1, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд 12.1 сая төгрөгийн 1, нийт 5,254.3 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг баталсан байна. Энэ нь анх баталсан төсөл, арга хэмжээнээс 300.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг хасаж, 755.1 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна. Үүнд:

Хасагдсан төсөл, арга, хэмжээний хувьд:

- Оршуулгын газрыг шинээр төлөвлөж, ажлыг эхлүүлэх 300.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ

Нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний хувьд:

- Засаг даргын тамгын газарт авто машины парк шинэчлэл 250.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Хүрэн морьтын давааны зам засвар /Малчин сумын/ 90.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Хар хэмийн амны зам засвар /Малчин сумын/ 85.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Хур хог булшлах, цэвэрлэх /Малчин сумын/ 30.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ
- Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сум 1-р баг/ 300.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ


Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасны дагуу 17 төсөл, арга хэмжээнээс техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай 8 төсөл, арга хэмжээ, зураг төсөв боловсруулсан 9 төсөл, арга хэмжээ байна.

Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Барилга байгууламжийн зураг төслийн магадлалыг энэ хуулийн 23.2-т заасан эх загвар зураг /эскиз/ болон ажлын зургийн үе шатуудад ажлын 15 өдөрт багтаан хийнэ”, Төсвийн тухай хуулийн 29.2.2 дахь заалт “Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх” гэж заасны дагуу Галдан бошигт хорооллын ус дулаан дамжуулах төсвийн барилгын ажил төсөл, арга хэмжээ нь 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 1833/2025 дугаар, Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс 1-р баг/ төсөл, арга хэмжээ нь 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1169/2025 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛСАН Ч 1 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БАТЛАГДСАН ТӨСВИЙГ 40.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

2.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг батлагдсан төсвөөс 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай (ТБОНӨХБАҮХАТ) хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.1-д “Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна”, 2.2-д “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж тус тус заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн цахим системд нийтэлсэн байна.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 6 төсөл, арга хэмжээний эрх шилжүүлж, аймгийн Худалдан авах ажиллагааны газар 10 төсөл, арга хэмжээний хүрээнд 14 худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 1 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, нийт 21 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

ТБОНӨХБАУХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно” гэж заасны дагуу 1 төсөл, арга хэмжээг 3 багц, 2 төсөл, арга хэмжээг тус бүр 2 багц болгон худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Хүснэгт 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа дараах байдалтай байна.

№	Төсөл, арга хэмжээ	Худалдан авалтын арга	Батлагдсан төсөвт өртөг /сая төгрөг/	Гэрээ байгуулсан дүн /сая төгрөг/
Эрх шилжүүлсэн				
1	ХЦ-ийн 0245-р ангийн штабын байрны засвар хийхэд дэмжлэг	ШХА	70.0	70.0
2	ХЦ-ийн 0311-р ангид шаардлагатай тоног төхөөрөмж	ШХА	30.0	30.0
3	Хүрэн морьтын давааны зам засвар /Малчин сум/	ХА	90.00	89.9
4	Хар хэмийн амны зам засвар /Малчин сум/	ХА	85.10	85.1
5	Хур хог булшлах, цэвэрлэх /Малчин сум/	ХА	30.00	30.0
6	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сумын нэгдүгээр баг/	НТШ	300.00	299.6
Аймгийн Худалдан авах ажиллагааны газар				
1	"Улаангом сумын хог хаягдал" төсөл арга хэмжээний хүрээнд "Төвлөрсөн хогийн цэгийн нөхөн сэргээлт"	НТШ	750.0	743.9
2	Төвлөрсөн хогийн цэг, оршуулгын газрын зөвлөх үйлчилгээ	ХА	100.0	98.3
3	Төвлөрсөн хогийн цэгт авто жин суурилуулах	НТШ	200.0	197.1
4	Багц 1: Авто машины парк шинэчлэл	НТШ	340.0	340.0

5	Багц 2: Авто машины парк шинэчлэл	НТШ	145.0	143.0
6	Багц 3: Авто машины парк шинэчлэл	ХА	75.0	75.0
7	"Улаангом сумын ногоон байгууламж, услалтын систем" төсөл арга хэмжээ Багц 1: Улаангом сумын М март-Баруун тойрог, Их наяд-Баруун тойрог чиглэл болон бусад зам талбайн тохижилт, ногоон байгууламж	НТШ	700.0	695.4
8	Багц 2: Улаангом сумын зам дагуух ногоон байгууламж, тохижилт	НТШ	300.0	296.4
9	Галдан бошигт хорооллын ус дулаан дамжуулах төвийн барилгын ажил	НТШ	610.0	607.8
10	Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр барих	ХА	108.0	107.5
11	"Тэс сумын дотуур байрны барилгын засвар, тохижилт"	НТШ	647.0	634.4
12	"Засаг даргын тамгын газарт-Авто машины парк шинэчлэлт"	НТШ	250.0	289.0
13	Багц 1: "Улаангом сумын авто замын засвар, шинэчлэлт"-ийн босоо тэмдэг суурилуулах ажил	НТШ	159.2	136.9
14	Багц 2: "Улаангом сумын авто замын засвар, шинэчлэлт"	НТШ	1,029.7	1,025.1
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс				
1	Усны эх үүсвэрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	ШХА	12.1	12.1

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

ТБОНӨХБАУХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ”, 48.2.1 дэх заалтад “худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах” гэж заасан байхад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Аймгийн 2025 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 37 дугаар тогтоолоор “Засаг даргын тамгын газарт-Авто машины парк шинэчлэлт” төсөл, арга хэмжээнд 250.0 сая төгрөгийн төсөв баталсныг 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөвт өртгийг 290.0 сая төгрөг болгон 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Цаашид батлагдсан төсөв, төлөвлөгөөний хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж байхыг зөвлөмж болголоо.



Нийт 21 худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 12 худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 6 худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, 3 шууд худалдан авалт хийсэн байна.

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт

өртгийн дээд хязгаар”-т заасан төсөвт өртөгт үндэслэн захиалагч тендер шалгаруулалтын аргыг зөв сонгон хэрэглэсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах 2 төсөл, арга хэмжээг төсөвт өртгөөс үл хамааран шууд худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт 4. Төсөвт өртгөөс үл хамааран шууд худалдан авалт хийсэн төсөл, арга хэмжээ, 2025 он

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	ХЦ-ийн 0245-р ангийн штабын байрны засвар хийхэд дэмжлэг	70.0
2	ХЦ-ийн 0311-р ангид шаардлагатай тоног төхөөрөмж	30.0

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх 2 төсөл, арга хэмжээний хувьд ТБОНӨХБАУХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Энэ хууль бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад хамаарахгүй”, 3.3.1 дэх заалтад “хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагаа” гэж заасныг баримталсан байна.

ТБОНӨХБАУХАТ хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ”, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Захиалагчийг төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Хүснэгт 5. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ, 2025 он

№	Төсөл, арга хэмжээ	Захирамжийн дугаар	Эрх шилжүүлсэн газар
1	ХЦ-ийн 0245-р ангийн штабын байрны засвар хийхэд дэмжлэг	Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр захирамж	Хилийн цэргийн 0245-р анги
2	ХЦ-ийн 0311-р ангид шаардлагатай тоног төхөөрөмж		Хилийн цэргийн 0311-р анги
3	Хүрэн морьтын давааны зам засвар /Малчин сум/		
4	Хар хэмийн амны зам засвар /Малчин сум/	Аймгийн Засаг даргын 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/301 захирамж	Малчин сумын Засаг даргын Тамгын газар
5	Хур хог булшлах, цэвэрлэх /Малчин сум/		
6	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сумын нэгдүгээр баг/	Аймгийн Засаг даргын 2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн А/435 захирамж	Тэс сумын Засаг даргын Тамгын газар

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Аймгийн Засаг даргын 2025 оны А/04 дүгээр захирамжаар 2 төсөл, арга хэмжээг Хилийн цэргийн 0245, 0311-р ангид, аймгийн Засаг даргын 2025 оны А/301 дүгээр захирамжаар 3 төсөл, арга хэмжээг Малчин сумын Засаг даргын Тамгын газарт, аймгийн Засаг даргын 2025 оны А/435 дугаар захирамжаар 1 төсөл, арга хэмжээг Тэс сумын Засаг даргын Тамгын газарт тус тус эрх шилжүүлсэн байна. Малчин сумын Засаг даргын Тамгын газар нь 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Тэс сумын Засаг даргын Тамгын газар нь 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр тус тус зарласан нь тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид хуулийн хугацаанд шилжүүлснийг харуулж байна.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

50.2. Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

50.2.1. тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах;

50.2.2. тендерийг нээх, хянан үзэх, үнэлэх;

50.2.3. захиалагчид энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргах зөвлөмж хүргүүлэх.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулсан 17 төсөл, арга хэмжээний 21 худалдан авах ажиллагаанд 14 үнэлгээний хороог ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 10.2-т зааснаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулна”, 50.1.1 дэх заалтад “100 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог гурваас доошгүй”, 50.1.2 дахь заалтад “ерөнхий гэрээний нэгдүгээр үе шатны, эсхүл энэ хуулийн 50.1.1-д зааснаас бусад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог таваас доошгүй” гэж заасны дагуу 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймаг, сумын Засаг даргын захирамжаар үнэлгээний хороог байгуулсан байна.


ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байна.”, 50.5 дахь хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүний гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байна”, 50.6 дахь хэсэгт “Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно” гэж тус тус заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл, Засаг даргын тамгын газрын ажилтан, тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулсан байна.

Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан гишүүдийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээг <https://user.tender.gov.mn/mn/exam/certificate> цахим системээс шалгахад 4 худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны гэрчилгээгүй 4 хүнийг гишүүнээр ажиллуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт “Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна”, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 2.11 дэх заалтад “Захиалагч үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилох мэргэшсэн ажилтныг мэргэшсэн ажилтны бүртгэлд бүртгэлтэй эсэх, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах хууль, журамд заасан

шаардлагыг хангасан эсэхийг шалгана” гэж заасантай нийцэхгүй байна. Цаашид үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны мэргэшсэн эрхийн гэрчилгээтэй иргэнийг ажиллуулах зөвлөмж өглөө.

ТБОНӨХБАУХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”, 11.2 дахь хэсэгт “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана” гэж заасны дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулжээ.

Зураг 1. Худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн хугацаа, тендер зарласан хугацаа дараах байдалтай байна. Үүнд:



Нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан 18 худалдан авах ажиллагаанаас 1 тендерийг төлөвлөсөн хугацаанаас өмнө, 4 тендерийг төлөвлөсөн хугацаандаа, 13 тендерийг төлөвлөсөн хугацаанаас 1-72 ажлын хоногоор хэтрүүлэн зарласан байна. Энэ нь тухайн бараа, ажил, үйлчилгээний зураг төсөв, техникийн тодорхойлолтыг захиалагч талаас хугацаа алдаж ирүүлснээс шалтгаалжээ. Цаашид худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаандаа зохион байгуулж байхыг холбогдох албан тушаалтанд зөвлөлөө.

Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр болон шилжин хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Аймгийн ИТХ-ын 2024.12.16-ны өдрийн “Увс аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 19 дүгээр тогтоол	Аймгийн ИТХ-ын 2025.06.13-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 37 дугаар тогтоол	Аймгийн ИТХ-ын 2025.07.18-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөвт тодотгол хийх тухай” 42 дугаар тогтоол
1	Шинэ хөрөнгө оруулалт	11	15	15
2	Шилжих хөрөнгө оруулалт	2	2	2
Нийт		13	17	17

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолууд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19 дүгээр “Увс аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолоор орон нутгийн төсвөөр 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан 13 төсөл, арга хэмжээнээс “Галдан бошигт хорооллын ус дулаан дамжуулах төвийн барилгын ажил” төсөл, арга хэмжээний тендерийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр нээлттэй зарласан ч ажлын зураг, төсөвт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон талаарх аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны 6/824 дүгээр албан бичгийг үндэслэн тендер шалгаруулалтыг түр зогсоон 10 дугаар сарын 14-ний өдөр үргэлжлүүлэн зарласан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална”, 13.1.1 дэх заалтад “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”, 13.1.2 дахь заалтад “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” гэж заасныг зөрчсөн байна.

Мөн Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.4 дэх заалтад “Төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон байхаар төлөвлөгөөнд тусгах, төсөвт тодотгол орсон бол төсөв батлагдсан даруйд хэрэгжүүлэхээр тусгана” гэж заасан байхад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 37 дугаар тогтоолоор 5 төсөл, арга хэмжээг нэмснээс 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төсөвт тодотгол хийхээс өмнө зохион байгуулсан нь хууль, журамд заасантай нийцэхгүй байна. Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

2.2 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан ч Сангийн яаманд сонгон шалгаруулалттай холбоотойгоор 1 гомдол гаргасан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана” гэж заасны дагуу 3 шууд худалдан авалтаас бусад 14 төсөл, арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 18 тендер шалгаруулалтын зарлалыг <https://user.tender.gov.mn/mn/invitation> цахим системд бүрэн нийтэлж тендер оролцогчдыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Мөн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Үнэлгээний хороо тендер нээсэн өдөр тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлнэ” гэж заасны дагуу 13 худалдан авах ажиллагааны материалыг тендер

нээсэн өдрөө хянан үзэж, үнэлэх ажиллагааг хийсэн бол 5 худалдан авах ажиллагааны үнэлгээг ажлын 1-5 хоногийн дараа хийсэн байна. Цаашид үнэлгээний хороо тендер нээсэн өдрөө хянан үзэж, үнэлэх үйл ажиллагаагаа эхлүүлж байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан 18 худалдан авах ажиллагааны гэрээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ”, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Захиалагч доор дурдсан тохиолдолд энэ хуулийн 30.1-д заасан хугацааны дараа гэрээ байгуулах хугацааг баримтлахгүй байж болно”, 30.2.1 дэх заалтад “тендер шалгаруулалтад нэг оролцогч тендер ирүүлж шалгарсан” гэж заасны дагуу байгуулсан байна.

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь эрх шилжиж ирсэн 3 төсөл, арга хэмжээний үр дүнг гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 112 хоногийн дараа нийтэлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ”, 48.2.5 дахь заалтад “тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтлэх” гэж заасантай нийцэхгүй байна. Цаашид тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Тендер оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээл байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана” гэж заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлагдсан 1 тендер оролцогч Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 4.6-д “... санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хуулийн 59.5-д заасныг үндэслэн хүлээн авахаас татгалзаж буцаана” гэж заасныг үндэслэн Сангийн яам гомдлыг хүлээн аваагүй байна.

Хүснэгт 7. Тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд гомдол гаргасан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гомдол гаргасан оролцогчийн нэр	Сангийн яамны шийдвэрлэлт	Эцсийн шийдвэрлэлт
1	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт	“Энх дормон” ХХК	Гомдлыг хүлээн аваагүй.	<ul style="list-style-type: none"> Сангийн яам гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцаасан. Шүүх захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгосон. /Нэхэмжлэгч шүүхэд гаргасан

нэхэмжлэлийн шаардлагаасаа
бүхэлд нь татгалзсан байна./

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

ТБОНӨХБАУХАТ хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 59.2-т зааснаар урьдчилан шийдвэрлүүлэх журмаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдол хянан шийдвэрлэхээс бусад тохиолдолд худалдан авах гэрээ байгуулснаас хойш гаргасан гомдлыг шүүхэд гаргана” гэж заасны дагуу тендерт оролцогч шүүхэд гомдол гаргасан бөгөөд шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаасаа бүхэлд нь татгалзсанаар шүүх нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсаныг баталж, хэрэгсэхгүй болгосон байна.

БҮЛЭГ 3. ГҮЙЦЭТГЭГЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТЛАГДСАН ЗУРАГ ТӨСӨВ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВРЫН ДАГУУ ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 1, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15, нийт 17 төсөл, арга хэмжээг 5,254.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр баталсан байна. Үүнээс 15 төсөл, арга хэмжээг тайлант онд шинээр хэрэгжихээр, 2 төсөл, арга хэмжээг өмнөх оноос шилжүүлэн хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр 16 төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд улсын комисс хүлээн авсан байна. Харин 1 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжиж байна.

Хүснэгт 8. Он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ

№	Аймаг, сумын нэр	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Улаангом	Галдан бошигт хорооллын ус дулаан дамжуулах төвийн барилгын ажил	610.0	110.0

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

3.2 Захиалагч нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтын чиг үүргээ хэрэгжүүлсэн ч эрх шилжүүлсэн 4 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга

хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.1-д “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар аймгийн Засаг даргатай 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан №01/2025 дугаартай гэрээний дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын актаар баталгаажуулж, гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан байна. Мөн гүйцэтгэл нь дууссан төсөл, арга хэмжээ бүрд Засаг даргын захирамжаар байгуулсан комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна.

Хүснэгт 9. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Гэрээний дүн /сая төгрөг/	Гүйцэтгэгч байгууллагын нэр
1	Улаангом сумын хог хаягдал төсөл арга хэмжээний хүрээнд Төвлөрсөнхогийн цэгийг цэгцлэх	750	743.9	Мөнхжим-Өргөө ХХК
2	Улаангом сумын ногоон байгууламж, услалтын систем төсөл арга хэмжээ багц 1 Улаангом сумын М март-Баруун тойрог, Их хаяд- Баруун тойрог чиглэл болон бусад зам талбайн тохижилт ногоон байгууламж	700.0	695.4	Содмандах ХХК
3	Улаангом сумын ногоон байгууламж, услалтын систем төсөл арга хэмжээ багц2 Улаангом сумын зам дагуух ногоон байгууламж, тохижилт	300.0	296.4	Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ
4	Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр	108.0	107.5	НББЭ ХХК
5	Тэс сумын дотуур байрны барилгын засвар, тохижилтын ажил	647.0	634.4	Гурван тэрмис ХХК
6	Улаангом сумын авто замын засвар, шинэчлэл багц 1 Улаангом сумын авто замын засвар, шинэчлэл	1,029.6	1,025.1	"Дүүрэн шим" ХХК
7	Улаангом сумын авто замын засвар, шинэчлэл багц 2 Улаангом сумын авто замын засвар, шинэчлэл	159.3	136.9	"Тод тунгалаг тэмдэг" ХХК

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ”, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Захиалагчийг

төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр захирамжаар Хилийн цэргийн 0245, 0311-р ангид 2 төсөл, арга хэмжээнд 100.0 сая, 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/301 дүгээр захирамжаар Малчин сумын Засаг даргын тамгын газарт 3 төсөл, арга хэмжээнд 205.1 сая, 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/435 дугаар захирамжаар Тэс сумын Засаг даргын тамгын газарт 1 төсөл, арга хэмжээнд 300.0 сая, нийт 605.1 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэнд тухайн сум, байгууллагын зүгээс хяналт хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 10. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжүүлэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
				Эхлэх	Дуусах		
1	ХЦ-ийн 0245-р ангийн штабын байрны засвар хийхэд дэмжлэг	ХЦ-ийн 0245-р анги	Их засвар хөрөнгө оруулалт	2025	2025	70.0	70.0
2	ХЦ-ийн 0311-р ангид шаардлагатай тоног төхөөрөмж	ХЦ-ийн 0311-р анги	Их засвар хөрөнгө оруулалт	2025	2025	30.0	30.0
3	Хүрэн морьтын давааны зам засвар	Малчин сумын ЗДТГ	Их засвар хөрөнгө оруулалт	2025	2025	90.0	90.0
4	Хар хэмийн амны зам засвар	Малчин сумын ЗДТГ	Их засвар хөрөнгө оруулалт	2025	2025	85.1	85.1
5	Малчин хур хог булшлах	Тэс сумын ЗДТГ	Их засвар хөрөнгө оруулалт	2025	2025	30.0	30.0
6	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сум/	Малчин сумын ЗДТГ	Их засвар хөрөнгө оруулалт	2025	2025	300.0	300.0
Нийт дүн						605.1	605.1

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт “Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно” гэж заасан байхад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх, хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулахгүй байгаа нь тухайн төсөл, арга хэмжээний чанар, үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж болзошгүй байна. Цаашид эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчин Тэс сумын Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлын 5.0 сая төгрөгийг Засаг даргын тамгын газрын тээвэр шатахууны өр төлбөрт зарцуулсанд албан шаардлага өглөө.

БҮЛЭГ 4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН 3 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ЗӨРҮҮТЭЙ ОЛГОСОН, 2 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ БҮРТГЭЛД БУРУУ ТУСГАСАН БАЙНА.

4.1 Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 24.9 сая төгрөгөөр илүү, 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 0.4 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заасны дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх 1, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 15, нийт 17 төсөл, арга хэмжээг 21 багц төсөл, арга хэмжээ болгон хэрэгжүүлснээс 20 төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авч санхүүжилтийг олгосон байна.

Бүрэн хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг илүү, 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дутуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх” гэж заасан байна.

Төвлөрсөн хогийн цэгийн нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч “Мөнхжим өргөө” ХХК-д 12.9 сая, Улаангом сумын ногоон байгууламж, услалтын систем төсөл, арга хэмжээний багц 1: Улаангом сумын М март-Баруун тойрог, Их наяд- Баруун тойрог чиглэл болон бусад зам талбайн тохижилт ногоон байгууламж төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч “Содмандах” ХХК-д 12.1 сая, нийт 24.9 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосонд төлбөрийн акт тогтоолоо.

Мөн “Хур хог булшлах, цэвэрлэх” /Малчин сум/ төсөл, арга хэмжээний гэрээний дүн 29.9 сая төгрөг байхад гүйцэтгэлээр 0.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонд төлбөрийн акт тогтоолоо.

Тайлант онд ажил нь хийгдэж дууссан ч баримт бичгийн бүрдэл дутуугаас санхүүжилт олгоогүй 2 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 190.4 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/666 дугаар захирамжаар барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт 11. Бүрэн хэрэгжсэн ч санхүүжилт дутуу, он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээ /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	Төсөл арга хэмжээний нэр	2025 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	2025 онд зарцуулаагүй санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн
1	Улаангом	Галдан бошигт хорооллын ус дулаан дамжуулах төвийн барилгын ажил	110.0	0.0	110.0
2	Тэс	Тэс сумын дотуур байрны барилгын засвар, тохижилтын ажил	430.2	349.8	80.4

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Эрх шилжсэн 3 төсөл, арга хэмжээг хүлээн авсан ч санхүүжилтийг бүрэн олгоогүй байна. Үүнд:

Хүснэгт 12. Бүрэн хэрэгжсэн ч санхүүжилт нь дутуу төсөл, арга хэмжээ

№	Аймаг, сумын нэр	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн зөрүү
1	Малчин сум	Хүрэн морьтын давааны зам засвар	90.0	80.1	9.9
2	Малчин сум	Хар хэмийн амны зам засвар	85.1	67.4	17.7
3	Тэс сум	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сум/	299.5	99.5	200.0

Эх сурвалж: 2025 оны ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.5-т заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.6.6 дахь заалтад “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасан байхад “Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байр” төсөл, арга хэмжээ нь 2024 онд гэрээ байгуулагдаагүй тул тухайн ажлын 60.0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/831 дүгээр захирамжаар барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор шилжих хөрөнгө оруулалт /2024-2025 он/ Тэс авто замын боомтод ГИХГ-ын албан хаагчийн амьдрах байрны санхүүжилтэд 2025 онд 48.0 сая төгрөг баталсан байна.

Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2024 онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 60.0 сая, 2025 онд шинээр баталсан 48.0 сая, нийт 108.0 сая төгрөгөөр зарлаж, 107.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон зөрчилд албан шаардлага өглөө.

4.2 Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг өмчийн бүртгэлд тусгасан ч 1 төсөл, арга хэмжээний бүртгэлийн дүн зөрүүтэй, 1 төсөл, арга хэмжээг буруу дансанд бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчиж Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт/Тэс сум/”-299.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын комисс хүлээн авсан байна. Тэс сумын Засаг даргын тамгын газар данс бүртгэлд тусгахдаа магадлашгүй ажил, зохиогчийн хяналтын зардлыг хасаж 285.9 сая төгрөгөөр бүртгэсэн байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд гэрээний дүнгээр бүртгэх зөвлөмж өглөө.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан “Төвлөрсөн хогийн цэгийн авто жин суурилуулах”-197.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлын даалгаварт зөөврийн сууц суурилуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлийн явцад хуучин байрыг засвар хийж ашиглахаар ажлын даалгаварт өөрчлөлт оруулж, гүйцэтгэгч компани 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Уг хөрөнгийг Улаангом хот тохижилт үйлчилгээ ОНТҮГ данс бүртгэлд тусгахдаа барилгын засварыг сайжруулалтаар орлого авахгүйгээр Авто пүүний үнэ дээр нэмж орлого авсан байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд үнэн зөв тусгах зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг журмын дагуу тооцож, байгууллага, иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг батлагдсан төсвөөс 40.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зохион байгуулсан байна.
3. Үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны гэрчилгээгүй 4 хүнийг гишүүнээр ажиллуулсан байна.
4. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг хэтрүүлэн 1,065.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
5. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг гэрээний хугацаанд хэрэгжүүлсэн байна.
6. Захиалагч нь эрх шилжүүлсэн 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.
7. Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 24.9 сая төгрөгөөр илүү, 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 0.4 сая төгрөгөөр дутуу олгосон байна.
8. Тэс сумын Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлын 5.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
9. “Тэс авто замын боомтод Гадаадын иргэн харьяатын газрын албан хаагчийн амьдрах байр” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2024 онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 60.0 сая, 2025 онд баталсан 48.0 сая, нийт 108.0 сая төгрөгөөр зохион байгуулж, 107.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлж санхүүжилтийг олгосон байна.
10. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 2 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 496.7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд буруу тусгасан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



УВС АЙМГИЙН
“УЛААНГОМ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ”
ОНТҮГ

Улаангом, Увс аймаг, 85160
Утас: 7045-4789, 7045-2128
Цахим шуудан: hot_tohijilt@yahoo.com

2026.05.08 № 196

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн хүрээнд манай байгууллага нь 197.1 сая төгрөгийн хөрөнгийг 2026 оны эхний хагас жилийн тайлан, данс бүртгэлд үнэн зөв задалж бүртгэх болно.

ЗАХИРАЛ  З.БАЛЖИННЯМ



8526910391



УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2012, 7045-2315, Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2026.05.08 № 6/871

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын "Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчилтэй холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлсэн "Хур хог булшлах, цэвэрлэх" /Малчин сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд гэрээний дүн 29.9 сая төгрөг байхад 0.4 сая төгрөгийн арифметик алдаа гарч, санхүүжилтийг дутуу олгосон зөрчлийг арилгаж ажиллана.

Цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүй байх, эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг чанд мөрдөн ажиллах болно.

БУС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ _____ М.МӨНХБАЯР



D disk: AZDTG_tamga A-4
8526080119



УВС АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-3262

2026.05.11 № 32

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Я.ШИЖИРБОЛД



8526430052

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, “Улаангом тохижилт үйлчилгээний” ОНТҮГ, Худалдан авах ажиллагааны газар “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байсан тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүй байх.
2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн Засаг дарга, Худалдан авах ажиллагааны газарт:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 дэх заалтыг мөрдөж ажиллах.

Тэс сумын Засаг даргад:

1. Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд гэрээний дүнгээр бүртгэх.

Тэс, Малчин сумын Засаг даргад:

1. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд мэргэшсэн эрхийн гэрчилгээтэй гишүүн томилон ажиллуулах.

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-т:

1. Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 197.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв бүртгэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТ-АМГАЛАН

Ч.МӨНХТОГТОХ

Т.ЗОЛОО

Т.АРИУНСАЙХАН

Б.НЯМБУУ

Увс аймаг, Улаангом-85160,
Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317
И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn